



ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ЗЭЭЛ

Бизнесийн зээл

Зээлийн танилцуулга

Энэхүү зээлээр бизнесийн эргэлтээ сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээнийхээ цар хүрээг тэлэх болон богино хугацааны санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжтой.

Танд ямар боломж, давуу тал бий болох вэ?

- Бизнесийн эргэлтээ сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээнийхээ цар хүрээг тэлэх
- Богино хугацааны санхүүгийн хэрэгцээгээ хангах
- Зээлийн шугам: шаардлагатай үедээ зээлээ ашиглаж, орлого орох тухай бүр зээлээс төлөлт хийх замаар хүүгийн зардлыг бууруулах

Зээлийн нөхцөл

Зээлийн хэмжээ:	350 сая төгрөг хүртэл	350 сая төгрөгөөс дээш
Зээлийн хүү /төгрөг/:	Жилийн 14.4% - 18.0% Сарын 1.2% - 1.5%	Зээлдэгчийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан уян хатан тогтооно.
Зээлийн хугацаа:	36 сар хүртэл	
Зээлийн шимтгэл:	0.3% (хамгийн багадаа 50,000 төгрөг)	
Тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none">• Эрхэлж буй бизнесийн чиглэлээр 1-ээс доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, төлбөрийн чадвартай байх;• ХХБ-ны зүгээс тавих бусад шаардлагыг хангасан байх	

Бүрдүүлэх материал

Хуулийн этгээдийн хувьд:

- Зээлийн хүсэлт – Байгууллага (маягт 069), санхүүгийн баримтад гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн мэдээлэл (Маягт 070);
- Улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Компанийн дүрэм;
- Зээл авах, компанийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол (ТУЗ);
- Санхүүгийн тайлан (сүүлийн нэг жилийн);
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз;
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар өмчлөх эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, шаардлагатай бол итгэмжлэл (эх хувь);
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд;
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
- Байгаль, орчин нийгмийн хариуцлагатай холбоотой баримт, материал;
- Зээлийн зарцуулалттай холбоотой бичиг баримтууд;
- Бусад шаардлагатай бичиг баримтууд.

Иргэдийн хувьд:

- Зээлдэгч, хамтран зээлдэгч тус бүрийн Зээлийн хүсэлт – Иргэн (Маягт 068);
- Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар (зээлийг хамтран хариуцах хүнд мөн адил хамаарна);
- Үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөл;
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар өмчлөх эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, шаардлагатай бол итгэмжлэл (эх хувь);
- Орлогын бүртгэлийн дэвтэр (хар дэвтэр), байгаа бол аж ахуйн нэгжийн сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд;
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
- Гэрлэлтийн гэрчилгээ (гэрлээгүй бол гэрлэсэн эсэх лавлагаа);
- Бусад шаардлагатай бичиг баримтууд.



дэлгэрэнгүй мэдээллийг:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn